



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 56

Номгон

Үндсэн хөрөнгө балансаас  
балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “а”, “в”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 40 дүгээр тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах журам”-ын 1.3, 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Галуут сумын Соёлын төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Чин сүзэгт номун ханы “Буян Арвидах” хийдийн түүхийн дурсгалт үнэт зүйлс, хашаа, суварга, 2009 онд ашиглалтад орсон 130,0 сая төгрөгийн өртөгөөр засвар хийж бүртгэсэн барилгын хамт аймгийн Түүх угсаатны зүйн Музейд үнэ төлбөргүй балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Балансаас балансад шилжүүлэх ажлыг комисс томилон зохион байгуулж, хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэж, тогтоолын хэрэгжилтийг 2019 оны 05 дугаар сард багтаан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албанд ирүүлэхийг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Идэрмөнх/-д даалгасугай.

3. Хийдийн харуул хамгаалалт, үйлчилгээний зардлыг жил бүрийн төсөвт тусгаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

1190045

D:/2018/Alban bichig/th togtool-2019